

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН 2020 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ САЙНЦАГААН СУМАНД
ХАМААРАЛТАЙ ЗААЛТЫН ХЭРЭГЖИЛТ

2020.10.10

№	Зорилт	Арга хэмжээ	Хүрэх түвшин үр дүнгийн үзүүлэлт	Хэрэгжилт	Хувь
НЭГ. ЗАСАГЛАЛЫН ХҮРЭЭНД					
<i>Тогтвортой, хариуцлагатай, ил тод төрийн албыг төлөвшүүлнэ.</i>					
1	1.1 Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах	1.1.1 Орон нутагт дутагдалтай байгаа нарийн мэргэжлийн боловсон хүчний дэлгэрэнгүй судалгааг гарган, төрийн албанд тогтвор суурьшилтай ажиллах нөхцлийг хангаж ажиллана.	- Байгууллага бүр дутагдалтай боловсон хүчнийг хангах арга хэмжээ авч, дутагдалтай мэргэжилтний 80-аас доошгүй хувийг хангасан байна.	Сумын хүний нөөцийг хөгжүүлэх хөтөлбөрийн дагуу байгууллагууд албан хаагчдын судалгааг,баг бүр мэргэжилтэй залуучуудын судалгааг жил бүр гаргадаг. Мэргэжилтэй боловсон хүчний хангалт 95% тай байна.	100
2		1.1.2 ТАХаагчдыг орон сууцаар хангахад хуулийн хүрээнд хөнгөлөлттэй зээлийн баталгаа гаргаж, мөнгөн дэмжлэг үзүүлэх	-	Энэ онд орон сууцанд шинээр орсон 1 албан хаагчид цалингийн зээлийн тодорхойлт гаргаж, ипотекийн 8% зээлд хамрагдлаа.	100
3		1.1.3 Төрийн албан хаагчдыг гадаад, дотоодод туршлага судлуулж, мэргэшүүлэх сургалтад хамрагдах боломжийг нэмэгдүүлнэ.	- Гадаад дотоодын сургалтанд хамруулж, сургалтанд хамрагдсан ТАХ-ын тоо өмнөх оноос 5 хувиар өссөн байна.	Цэцэрлэгийн багш нар Улаанбаатар хотын Баянгол дүүргийн 161, 68, улсын тэргүүний 30-р цэцэрлэг, Өвөрхангай аймгийн 1,5 -р цэцэрлэгт 25 албан хаагч туршлага судаллаа. Бусад аймаг сумаас 107 багш туршлага судаллаа. Өмнөговь аймгийн Даланзадгад хотноо төвийн бүсийн хотуудын ЗДТГазрын албан хаагчдын сургалтанд 25 албан хаагчид хамрагдлаа.	70
4		1.1.4 Багийн Засаг дарга нарыг унаажуулах ажлыг үе шаттай шийдвэрлэнэ.	- Унаажуулсан хувиар	Тус сумын багийн засаг дарга нарын 88.8 % нь мотоцикльтой боллоо.	70
5		1.1.5 Төрийн үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэх замаар иргэдэд ил тод, шуурхай, хүртээмжтэй, үйлчилгээг хүнд сурталгүй хүргэх, цахим засаглалыг бодитойгоор хэрэгжүүлнэ.	- Цахимаар мэдээлэл авах төрийн үйлчилгээний төрлийг, нэмэгдүүлж, өмнөх оноос 20 хүртэл %-иар өсгөн	Цахим системийн /ХУР/ үйлчилгээний тоног төхөөрөмжөөр 53 төрлийн үйлчилгээг иргэдэд хүргэх ба 2020 оны 08 сарын 25-нээс эхлэн 340 иргэнд 6 төрлийн лавлагааг гаргаж, төрийн үйлчилгээ үзүүллээ.	100
6		1.1.6 Төрийн үйл ажиллагаанд иргэд иргэний нийгмийн байгууллага, мэргэжлийн холбоодын хяналтыг бий болгож, төрийн зарим чиг үүргийг гэрээгээр гүйцэтгүүлэх	- ТББ байгууллагуудтай гэрээ байгуулж, хамтарч ажилласан байна.	Засаг даргын захирамжаар харъяалалгүй 137 ахмад настанг ААНэгж, албан байгууллагад харъяалууллаа. Сумын ахмадын хорооны хамтран ажиллах 4 зорилт бүхий 20 арга хэмжээ төлөвлөн хэрэгжүүлээ.	70

7	1.1.8 Малчдыг аюулгүй орчинд ажиллаж, амьдрах, мэдээллээр хангаж, орон зайн тэгш бус байдлаас үл хамааран сум, багийнхаа үйл ажиллагаанд жигд оролцох боломжоор хангана.	- Малчдыг мэдээллээр хангаж, байгалийн аюулт үзэгдлээс урьчилан сэргийлэх арга хэмжээг авах	Төрийн албан хаагч сургууль, цэцэрлэгүүд 37 удаагийн мэдээллээр иргэд, 185 малчин өрх байгалийн гэнэтийн аюул, гамшгаас сэргийлэх болон цаг үе, хууль тогтоомжийн мэдээлэл хүргэлээ.	70
8	1.2.6 Архивын баримт бичгийн 90 хувийг цахим хэлбэрт шилжүүлж, мэдээллийн нэгдсэн систем бүрдүүлэх, төрийн архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг сайжруулах		Бүх байгууллагын архив, албан хэрэг хөтлөлтийн ORG-AMS программыг ашиглаж байна. Харьяа байгууллагуудын бичиг хэргийн ажилтнууд архивын материалыг цахимжуулах ажил хийгдлээ. Мөн ирсэн, явсан бичгийг цахимаар бүртгэх, иргэдэд лавлагаа /92/ өгөх ажлуудыг тогтмол хийж байна.	100
9	1.2.7 Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлж бүх шатанд авлигаас ангид, ашиг сонирхлын зөрчилгүй ил тод, нээлттэй, итгэл даах байдлыг хангана.	- Хөтөлбөрийн хэрэгжилтийн хувийг улсын дунджаас бууруулахгүй ажиллана.	Ажлын байрны томилгооны зөрчилгүй ажиллаж, ХАСХОМ гаргагч нар хуулийн хугацаанд мэдүүлгээ цахимаар гаргалаа.Авилга ашиг сонирхолтой холбоотой зөрчил гомдол гараагүй болно.	100
10	1.3.4 “Архигүй Дундговь” хөтөлбөрийг хэрэгжүүлж архидалтгүй орчин бүрдүүлэхэд чиглэсэн иргэд болон иргэний нийгмийн байгууллагын үйл ажиллагааг дэмжинэ.	- төрийн болон ТББ-уудтай хамтран хэрэгжүүлж, согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчил буурсан байна.	“Сархадгүй Сайнцагаан” хэсэгчилсэн арга хэмжээг иргэдэд танилцуулга хуудас болон цахим хэлбэрээр хийлээ. Сумын хэмжээнд согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг 32 байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 0.8 хувиар буурсан үзүүлэлттэй байна.	70
11	1.3.5 Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, хүүхдийг гэмт хэрэг, осол, зөрчилд өртөхөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд бүх шатны төрийн болон ТББайгууллагуудыг татан оролцуулж, салбар дундын байгууллагуудын хамтын ажиллагаа, үүрэг хариуцлагыг сайжруулна.	- Гэр бүлийн хүчирхийллээс үүдэлтэй болон бусад хэлбэрийн хүүхдийн эрхийн зөрчил буурсан байна.	Сумын ИТХурал, Цагдаагийн газар, Оюуны гэгээ төрийн бус байгууллагатай хамтран сумын засаг даргын А/75 захирамжийн дагуу гэр бүлийн харилцаа хандлага, хүүхэд хүмүүжүүлэх эерэг арга, хамтарсан багийн талаар болон холбогдох хууль тогтоомжийг цахимаар сурталчилж, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх зорилготой “Гэр бүлийн хүчирхийллийн эсрэг хамтдаа” цахим нөлөөлийн сарын аяныг “ХАРУУСАЛ БИШ –ХАЙР ӨВЛҮҮЛБЕ” уриан дор зохион байгууллаа. Сумын ЗДТГазрын пэйж хуудсаар цахим аяны 13хүрээнд 10 төрлийн постер, 18 төрлийн видео бичлэг түгээж 253 хүн хуваалцаж давхардсан тоогоор 17534 тандалт авсан байна. Судалгааны дагуу хүчирхийлэлд өртөж болзошгүй 37 хүүхэд , гэр бүлийн хүчирхийлэлтэй 14 өрхөөр сумын хэсгийн байцаагч, багийн нийгмийн ажилтан, Цагдаагийн газрын хүүхдийн байцаагч, Оюуны гэгээ ТББайгууллагатай хамтран нөхцөл байдалтай танилцаж, мэдээ мэдээлэл, зөвлөгөө өглөө.	100

12	1.3.6 Сумдын хэсгийн төлөөлөгч, цагдаа нарыг мэдээллийн сүлжээнд холбох, алба хаагчдыг унаажуулах, согтуурал хэмжигч багаж бэлэн бус торгуулийн системийг цагдаагийн үйл ажиллагаанд бүрэн нэвтрүүлэх асуудлыг үе шаттай шийдвэрлэж, цагдаагийн байгууллагын ажил үйлчилгээг түргэн шуурхай, иргэдэд чирэгдэлгүй хүргэх нөхцөлийг бүрдүүлэх	-	Тус сумын бүртгэлтэй компьютер, сейф, принтерийг цагдаагийн хэсгийн төлөөлөгч албан хэрэгцээнд ашигладаг. Хөдөө ажлаар явах шаардлагатай тохиолдолд мотоциклиор, бичгийн цаас 4 боодол, 90 л шатахуунаар тус тус дэмжлэг үзүүллээ. Үйл ажиллагааг нь дэмжин сумын ОНХСангийн хөрөнгөөр Приус-30 авто машин худалдан авч хүлээлгэн өглөө.	100
13	1.3.7 Мал сүргийг хамгаалах, мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэхэд чиглэсэн малчдын бүлэг, нөхөрлөлийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж малын хулгайн гэмт хэргийн гаралтыг бууруулна.	- Малчдын бүлэг, иргэдийн үйл ажиллагааг идэвхжүүлэн малын хулгайн гэмт хэргийн гаралтыг бууруулна .	Сумын малчин өрхүүдийн дунд нэг сарын хугацаатай аяны богц аялуулж, малын хулгайн гэмт хэргийн мэдээлэл, гарын авлага 20 ширхэг тарааж, танилцуулга мэдээллийг цахимаар хүргэлээ. Цахимд 23 өрхийн 157 иргэний тандалттай байна. Малын хулгайн гэмт хэрэг өмнөх оноос 26,3 хувь буурсан үзүүлэлттэй байна.	70
Хэрэгжилт -86.15%				
ГУРАВ. НИЙГМИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД				
<i>Иргэдийн эрүүл аюулгүй орчинд сурч хөгжих, ажиллаж амьдрах таатай орчин нөхцлийг бүрдүүлж, нийгмийн үйлчилгээнд тэгш хүртээмжтэй хамрагдах боломжийг бий болгох замаар хүний хөгжлийг хангаж, нийгмийн баталгааг нь сайжруулна.</i>				
14	3.2.10 “Хүүхдэд ээлтэй дотуур байр” хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх	-	2020-2021 оны хичээлийн жилд 2 сургуулийн дотуур байранд нийт 165 хүүхэд амьдарч байна. Хөтөлбөрийн хүрээнд хүүхдэд ээлтэй таатай орчин бүрдүүлэх зорилгоор гадна болон дотор тохижилтонд 3025000 төгрөгийн засвар хийлээ.	70
15	3.2.11 Явуулын тусламж үйлчилгээгээр алслагдсан сум, баг, малчин иргэдийг эрүүл мэндийн урьдчилсан сэргийлэх үзлэгт хамруулах	- Нийт иргэдийн 25 хувийг хамруулж, өвчлөл илэрсэн иргэдийн 40 хувийг эрүүлжүүлнэ	Хөдөөгийн 4 багийн 248 өрхийн 878 иргэнд явуулын тусламж үйлчилгээгээр урьдчилан сэргийлэх үзлэг хийлээ. Үүнээс хүүхэд-192, ХБИргэн-21, ахмад настан-63 байлаа.	100
16	3.2.12 Сургалтын үйл ажиллагаа бэлтгэж, төлөвлөхөд дэмжлэг үзүүлэх зорилгоор СӨБ-д “Ээлжийн багш” ажиллуулах боломжийг судлан, хамран сургалтыг нэмэгдүүлнэ.	- СӨБ-ын хамран сургалтыг 3 хувиар нэмэгдүүлнэ.	Тус сумын 2020-2021 оны хичээлийн жилд 2-5 насны 1610 хүүхэд цэцэрлэгт хамрагдахаас БШУЯ-ны сайдын 17-р тушаалын дагуу 2 настай 415 хүүхэд цэцэрлэгт хамрагдаагүй байна. Хамрагдвал зохих 3-5 настай 1195 хүүхдээс 1078 хүүхэд хамрагдаж байна. Хамран сургалт 90% байна.	100
Хэрэгжилт-90%				
ДӨРӨВ. ХҮНС ХӨДӨӨ АЖ АХУЙ, ҮЙДВЭРЛЭЛИЙН ХҮРЭЭНД				
<i>Хүнс, хөдөө аж ахуйн салбарын тогтвортой хөгжлийг хангаж ажиллана.</i>				
17	4.1.1 “Монгол мал” үндэсний	- Төлөвлөгөөний	“Монгол мал” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх сумын	70

	хөтөлбөрийн 2 дахь үе шатыг хэрэгжүүлэх аймгийн төлөвлөгөөг хэрэгжүүлнэ.	хэрэгжилтийг 90 хувьд хүргэнэ.	төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд 43 заалт тусгаснаас хэрэгжилт 70 хувьтай байна. НҮБ-ын аж үйлдвэрийн байгууллага, МУ-ын ХЭД хөтөлбөр, төслийн хүрээнд хонины ноосны чанар сайжруулах олон улсын сургалтыг ХХААХҮЯам, аймгийн ЗДТГ, сумын ЗДТГ хамтран Далай багт 7 хоногийн сургалтыг зохион байгууллаа.	
18	4.1.4 Бэлчээрийн даацад тулгуурлан мал аж ахуйг хөгжүүлэх, бэлчээрийн ашиглалт, хамгаалалтыг сайжруулах, бэлчээрийн менежментийн төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлнэ.	Бга-аас доошгүй талбайд бэлчээрийн хөнөөлт мэрэгчид, хортон шавьжтай тэмцэх ажлыг энгийн механик болон микро биологийн аргаар малчдын оролцоотойгоор хийх	Бэлчээрийн ашиглалт хамгаалалт сайжруулах зорилгоор хөнөөлт хортон шавьжтай тэмцэх ажлын хүрээнд 5 мянган га бэлчээрт энгийн болон механик аргаар 2 мянган га-д микробиологийн аргаар хортон шавьжтай тэмцсэн. 78-82,5% гүйцэтгэлтэй.	70
19	4.1.5 Тэмээний амьдын ашиг шим /ноос, сүү, уналгаа эдэлгээ/-ийг нэмэгдүүлж, тэмээгээ өсгөсөн баг малчдыг дэмжиж ажиллана.	-Тэмээ өсгөсөн малчдыг урамшуулна - Тэмээн сүргийн тоо толгойг 2 хувиар өсгөнө.	Жилийн эцсээр 1306 тэмээ тоологдож, өмнөх оноос 9.2 хувиар буурсан үзүүлэлттэй байна. “Алтан ботгоны эзэн”-ээр Үйзэн багийн малчин Д.Сумъяасүрэн шалгарлаа	40
20	4.1.6 Сумын хэмжээнд жилдээ 4-аас доошгүй гүний худаг, 30-аас доошгүй гар худаг засварлах буюу шинээр гаргаж, бэлчээрийн усан хангамжийг тогтмол нэмэгдүүлэн хяналт тавина.	- Гүний 1 худаг, энгийн уурхайн 8 худаг сэргээн засварлаж бэлчээрийн усан хангамжийг өмнөх оноос 2 хувиар нэмэгдүүлнэ.	Сумын ОНХСангийн 16,0 сая төгрөгний хөрөнгөөр 8 энгийн уурхайн худаг засварлахаар шийдвэрлэн одоогоор 6 худаг засварлах ажлыг “Халзан хайрхан” иргэдийн бүлэг хийж гүйцэтгэлээ. Үлдсэн 2 худгийн хувьд ОНХСангийн санхүүжилт хийгдэхгүй байгаа тул ажил хийгдээгүй байна.Улсын төсвийн хөрөнгөөр гүний худаг 3-ыг гаргах ажил тус суманд батлагдсан ч тендер шалгаруулалтыг аймгийн орон нутгийн өмчийн газар зохион байгуулж гэрээ байгуулах шатандаа явж байна.	70
21	4.1.7 Өндөр ашиг шимт сүүний чиглэлийн аж ахуйг хөгжүүлэн, малын тоог чанарт шилжүүлж, ашиг шим хүртээмжийг сайжруулна	- Үхрийн аж ахуй болон тэмээний аж ахуйг дэмжиж, өндөр ашиг шимт малын тоог 10-аар нэмэгдүүлнэ	Иргэдээс зээлийн төсөл ирээгүй	ҮБ
22	4.1.8. Гахай, шувууны туслах аж ахуйг хөгжүүлэх санал санаачилгыг дэмжинэ.	- Гахай, тахиа, шувууны, аж ахуй эрхэлж буй аж ахуйн нэгжүүд болон шинээр 3-аас доошгүй ААН, иргэнд зээлийн дэмжлэг үзүүлнэ	2017-2019 онд гахайн аж ахуйн чиглэлээр 2 иргэнд 40,0 сая, тахианы аж ахуй эрхлэх чиглэлээр 1 иргэнд 30,0 сая төгрөгийн төслийг СХС-аас дэмжсэн. Одоогоор дээрх чиглэлийн аж ахуй эрхлэх хүсэлт иргэдээс ирээгүй болно.	40
23	4.1.11. Малын эмчийг орон нутагт тогтвор суурьшилтай ажиллуулах, мал эмнэлгийн үйлчилгээг эрхлэх боломжийг	- Баг бүрт хувийн хэвшлийн мал эмнэлгийн нэгжтэй болж, үйлчилгээний	Сумын хөдөөгийн баг бүр хувийн мал эмнэлгийн нэгжтэй боллоо. Малын эмч нартай хамтран малчдад үйлчилгээ үзүүлэн,материаллаг баазыг дэмжих зорилгоор 2 багт мал угаалгын суурин баннтай болж, сумын хэмжээнд үхэр 3415,	100

		бүрдүүлэн материаллаг баазыг бэхжүүлж, үйлчилгээний хүртээмж, чанар, үр нөлөөг сайжруулна.	чанар, хүртээмжийг сайжруулна.	бог мал 389225-ыг угаалганд хамрууллаа.	
24		4.1.12 Малын гоц халдварт, халдварт өвчинөөс урьдчилан сэргийлэх, бруцеллёз өвчинтэй тэмцэх стратегийг хэрэгжүүлэх арга хэмжээг тогтмол зохион байгуулах	-	ДХХ халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтанд 41 өрхийн хонь 21742, ямаа 21236 нийт 42978 малыг хамрууллаа. Бруцеллёз өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтанд 252 өрхийн тугал-195, хурга-22759, ишиг-16543 нийт 39497 мал хамрууллаа.	100
25	4.2Үйлдвэрлэл үйлчилгээ, хүнс худаа	4.2.3. Мал нядалгааны цэгтэй болж улмаар хүнсний захуудад орон тооны малын эмчийг тогтмол ажиллуулан эрүүл ахуйн шаардлагад нийцсэн махаар хүн амын хэрэгцээг тасралтгүй хангана.	- малын эмчийг тогтмол ажиллуулах, мал эмнэлэг, ариун цэврийнгэрчилгээ, шинжилгээний бичиг, дүгнэлттэй худалдаа үйлчилгээ явуулсан байх	Сумын төвд мал нядалгааны 3 цэг үйл ажиллагаа явуулж байна. 2019 оны 11 сараас эхлэн малын эмчтэй гэрээ байгуулан ажиллуулж байна. Малын эмч нь нядалгаанд орж байгаа малын эрүүл мэндэд үзлэг хийх, шаардлагатай үед аймгийн Мал эмнэлгийн лаборторит дээж өгч шинжлүүлэх, гарал үүслийг тогтоож цахим системд бүртгэж нэгтгэх зэрэг ажлыг гүйцэтгэхээс гадна нядалгааны газрын цэвэрлэгээ, эрүүл ахуйн шаардлагад хяналт тавьж байна. Мал нядалгааны 1 цэг нь зээлэнд хамрагдаж шинээр байртай болж, 2 цэг нь гадна хашаагаа шинэчилж бүрэн засвар хийлээ.	70
26		4.2.4. Нийтийн хоол, зочид буудал болон бусад үйлчилгээний чиглэлээр орчин үеийн стандарт, шаардлагад нийцсэн үйлчилгээний төвийг байгуулах санаачилгыг дэмжинэ.	- Аж ахуйн нэгжид мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч холбогдох байгууллагуудтай хамтран ажиллана	-“Дэлгэрэх бүрд” ХХК-тай хамтран 1 сарын хугацаатай “Ажилтан бүр шинэ санаачилга” сэдэвт уралдааныг зохион байгууллаа. Уралдаанд 11 ажилчин оролцлоо. Хоол үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч 22 газраас 17 газарт “Хоол үйлдвэрлэлийг шалгах хяналтын хуудас”-аар үнэлгээ хийж, дундаж нь 88 %тай үнэлэгдлээ. Аймгийн МХГазартай хамтран 4 зоогийн газарт төлөвлөгөөт шалгалт хийж, бага эрсдэлтэй үнэлэгдлээ.	70
27		4.2.7. Ажлын байр шинээр бий болгосон, шинэ нэр төрлийн үйлдвэрлэл үйлчилгээ нээсэн, бүтээгдэхүүнээ гадаад дотоодын зах зээлд нийлүүлж буй бизнес эрхлэгчдийг дэмжинэ.	- ШАБайрны тоо, борлуулалтын орлого өссөн байна.	Сумын тэргүүлэх чиглэлийн дагуу ЖДҮйлдвэр, үйлчилгээ эрхлэгч барилгын материал үйлдвэрлэлийн чиглэлээр 1 иргэнд 17 сая, ХАА, газар тариалангийн чиглэлээр 1 ААН, 7 иргэнд 199 ,0 сая, хөнгөн үйлдвэрийн чиглэлээр 2 ААН, 4 иргэнд 173,0 сая нийт 15 төсөлд 389,0 сая төгрөгийн зээлийг олголоо. Дээрх төрлийн хөнгөлөлттэй зээлийн хүрээнд шинээр 49 ажлын байрыг бий болгосон нь өмнөх оноос 50 хувиар нэмэгдлээ.	70
28		4.2.10.Орон нутгийн хөрсөнд ургасан хөмүүлийг үйлдвэрлэлийн аргаар боловсруулах үйлдвэр, цех байгуулж,хүн амыг экологийн цэвэр хүнсээр хангах санаачлага гаргасан үйлдвэрлэгчийг дэмжиж ажиллана.	- Хөмүүлийг үйлдвэрлэлийн аргаар боловсруулан, савлах санал санаачилгыг дэмжинэ.	Иргэдээс зээлийн төсөл ирээгүй	ҮБ
Хэрэгжилт -70%					

ЗУРГАА. БҮТЭЭН БАЙГУУЛАЛТ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХҮРЭЭНД					
29	Барилг, хот байгууллагын хүрээнд	6.1.1 Аймгийн төвд 35 мВт хүчин чадалтай дулааны станц, 4 км шугам хоолой, дулаан дамжуулах төвийн барилгыг барьж, айл өрх, албан байгууллагуудыг хэрэглээний халуун ус, дулаанаар хангана.	- Аймгийн төвд 20 мВт хүчин чадалтай дулааны станцын ажлын зураг төсвийг хүлээн авна. - 2-р хэлхээний дулааны шугам сүлжээний зураг төсвийг боловсруулан хүлээн авна.	-	ҮБ
30		6.1.4. Олгойн говийн цэвэр усны 35 кВт-ын 30 км ЦДАШ, 6 дэд станц, тулгуурыг солих, төвийн гэр хорооллын суурьшлын шинэ бүсийн цахилгааны хангамжийг сайжруулах арга хэмжээ авна.	- Олгойн говийн цэвэр усны 35 кВт-ын 8км ЦДАШ-ын ажлыг гүйцэтгэнэ.	Хугацаа болоогүй	-
31		6.2.6 Сумын ЗДТГ-ын конторын барилгыг шинээр барина	- Конторын барилга ашиглалтанд орно.	Барилгын зураг төсөл хийгдэж,холбогдох газар хүргүүллээ.	40
32		6.2.9. ГИЦСургуулийн спортын талбайг тохижуулна.	- ГИЦС-н спорт талбайн тохижилтын ажлыг 100 хувь гүйцэтгэнэ	Сургуулийн спорт тоглоомын талбайн тохижилтыг улсын төсвийн 178,1 сая төгрөгөөр “Мандал шилтгээн”ХХКомпани хийж,ашиглалтанд орууллаа.	100
33		6.2.13 Гэр хорооллын гудамжуудыг цэгцлэх, хөндлөн гарц гаргаж, хашааг жигдрүүлэх, тохижуулах ажлыг иргэдийн оролцоотой хэрэгжүүлнэ.	- Гэр хорооллыг тохижуулсан байна.	Сумын төвийн гэр хорооллын багуудад багийн засаг дарга нар иргэдтэй хамтран хашааны зос буулгаж одоогоор 260 өрх хашаагаа зосдлоо. Зарим багууд хашааны хаалганд хээ тавих, будах зэргээр 61 өрх хашаандаа тохижилт хийлээ.	70
34		6.2.14 “Гэрэлтэй Мандалговь”, “Ногоон Мандалговь”, “Шинэ гудамж” төслүүд хэрэгжүүлнэ.	- Төсөл хөтөлбөрүүд хэрэгжсэн байна.	Сумын ОНХСангийн хөрөнгөөр Буяннэмэхийн гудамжны 53 гэрлийн шонд 9.540.000 төгрөгний өртөг бүхий гоёлын гэрэлтүүлгийг “Мосума корпараци” ХХК гүйцэтгэснийг хүлээн авч одоогийн байдлаар суурилуулах ажил хийгдэж байна “Ногоон Мандалговь” дэд хөтөлбөрийн хүрээнд 15600 цэцэг, 2 га талбайд 2415 ш мод суулган сургууль, цэцэрлэгийн гадна талбайд 9000 ширхэг мандалын цэцгийг тарьж, 300 ш хайлаас, хуайс, 72 мкв зүлэгжүүлэлт, арчлалт хамгаалалтыг хийлээ.	70
Хэрэгжилт-70%					
Нийт хэрэгжилт-79.0%					